



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ӨЛЗИЙГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 09 өдөр

Дугаар

A/69

Улаан-Уул

Тариалангийн талбайг  
хамгаалах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар 66.1, 66.3, Тариалангийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.2 дахь заалт, Газрын тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3, Зөрчлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2, 13.6.1, 13.6.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Жил бүр тариалангийн талбайд үр суулгаснаас эхлэн ургац хурааж дуусах хүртэлх хугацаанд 3 км-ээс дотогш зайд малтай айл нутаглах, талбайд мал, амьтан оруулахыг хориглосугай.

2.Өөрийн эзэмшлийн талбайдаа хашаа хамгаалалт хийж, харуул хамгаалалтыг тогтмол ажиллуулах, голын гольдирлыг хааж, өөрчлөн ус татахгүй байх, ил задгай бие засах, хог хаягдал хаяхгүй байх, талбайн хамгаалалтын хашаан дотор гэр, майхан барихгүй байх, тэрбум мод хөдөлгөөний хүрээнд тариалангийн талбайд суулгасан мод бутыг хамгаалж, арчилах, талбай дундуур машин техниктэй явахгүй байхыг нийт тариаланчдад үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, тухайн бүс нутгуудад нутаглаж байгаа малчид, тариаланчдад танилцуулж зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг багуудын Засаг дарга нар, Хөдөө аж ахуйн тасаг болон Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, Экологийн цагдаа нарт даалгасугай.

5.Энэ захирамж гарсантай холбогдуулан 2021 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн А/97 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Т.ЭРДЭНЭБАТ



642201121

Сумын Засаг даргын *М.Л.Л* оны  
*А.В.Л* сарын *12*-ны өдрийн  
дүгээр захирамжийн хавсралт

### ЧӨЛӨӨЛӨГДӨХ ГАЗАР НУТГУУД

#### А.Бумбатад

1. Цэргийн байрнаас Уу хөндий амны голын урд тал
2. Тоосгоны үйлдвэрийн дээд тохойн дэрс
3. Ялаат булаг
4. Номгоны өвдөг, ногооны талбайн хойт хэсгийн нутаг

#### Б.Хөшөөт

1. Талбайн дагуу голын хойд талын нутаг
2. Хар хошуунаас дотгош ногооны талбай хүртэл
3. Талбайн доод үзүүрээс тоосгоны үйлдвэрийн дээд тохой хүртэл

#### В.Бор балгасанд

1. Хотын хөмөг, хойт тал
2. Бор балгасны тариалангийн талбайн дээд, доод хэсгийн гол дагуу нутаг

-----oO-----